



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/645

Ховд

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 143 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Буянт баг Хөгжлийн 1 дүгээр гудамжны 102 тоотод байрлах амины орон сууцны зориулалттай Мөнхтүвшингийн Төрхүү /ПЖ96083118/-ийн эзэмшлийн 1142 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу "Авид дэвшил" ХХК /4091949/-д шилжүүлж, худалдаа, үйлчилгээний зориулалттай болгон 9 жилийн хугацаагаар,

2. Жаргалант сумын Рашаант баг Хуульчдын 1 дүгээр гудамжны 04 тоотод байрлах худалдаа, үйлчилгээний зориулалттай Батсүхийн Алтанбадралт /ПК81053018/-ийн эзэмшлийн 24 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Шекений Алмагүль /ПВ80112301/-д шилжүүлж, хаягийг Усны 1 дүгээр гудамжны 112 тоот болгон 10 жилийн хугацаагаар тус тус шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

3. Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлэн авч, газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, ашиглаж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлэхийг дээрх иргэн, аж ахуй нэгжид үүрэг болгосугай.

4. Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэн, аж ахуй нэгжтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Дөлбадрал/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02 2021  
Zah A/645 Kh